



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын зарим тусгай сангийн үйл ажиллагаа, үр дүнд Үндэсний Аудитын газрын хийсэн аудитын тайланг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай:

1/Хүний хөгжил сангаас иргэдэд бэлэн мөнгө олгох явцад давхардуулан олгосон зөрчил үүсгэсэн холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцох, цаашид бүртгэлийн асуудлыг боловсронгуй болгох, сангийн зарцуулалтад тогтмол хяналт тавьж ажиллах, тус сангийн зарлагыг төсвөөс өглөг үүсгэж санхүүжүүлдэг тогтолцоог арилгах асуудлаар холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;


2/Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банкинд байршуулахдаа арилжааны банкны хадгаламжийн хүүгийн түвшинтэй адилтган хүүг тогтоох талаар судалж, хэрэгжүүлэх;

3/Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд архи, тамхины хор холбогдлын тухай хичээл ордог байхаар сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, түүнд зарцуулах зардлыг Эрүүл мэндийг дэмжих сан болон Архидан согтуурахтай тэмцэх сангаас гаргах эрх зүйн орчинг бүрдүүлэх боломжийг судалж, хэрэгжүүлэх;

4/Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаас хөрөнгө оруулалт хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны явцад бий болсон өмч хөрөнгийн бүртгэл хийх эрх зүйн орчинг бий болгох.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, Үндэсний Аудитын газар /А.Зангад/-т тус тус даалгасугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ДАВААСҮРЭН